

”ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 03-р сарын 16 өдөр

Дугаар 02/2020

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын холбогдох заалтуудыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03-р сарын 16-ны өдрийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04-р сарын 29-ний өдөр 14.00 цагт Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 тоот хаягаар орших компанийн өөрийн байр, хурлын танхимд хуралдуулсугай.
2. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурдсан асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай:
 - 2.1. Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
 - 2.2. Компанийн 2019 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
 - 2.3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах,
 - 2.4. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах.
3. 2020 оны 04-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн П.Учралыг томилсугай.
4. Хурал зохион байгуулах комиссын даргаар Б.Ганбат, комиссын гишүүдээр Д.Дашмаа, С.Нямхүү нарыг томилсугай.
5. Хурлын тооллогын комиссын даргаар М.Шавагцэрэн, комиссын гишүүнээр Э.Ариунаа нарыг томилсугай.
6. Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу

хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хүргэх, хурлыг зарлан хуралдуулах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комиссод даалгасугай.

7. Covid 19 коронавирусын тархалттай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 онд хэрхэн зохион байгуулж хуралдуулах талаар СЗХ, МХБ-с гаргах тогтоол, шийдвэр, зөвлөмжийг анхаарч ажиллах, хэрвээ коронавирусын тархалтаас үүдэн хурлыг товлосон өдөр хуралдуулах боломжгүй нөхцөл байдал үүсвэл энэ тухай СЗХ, МХБ болон хувьцаа эзэмшигчдэд нэн даруй мэдээлэхийг хурал зохион байгуулах комиссод даалгасугай.
8. Энэхүү ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 04-р сарын 06-ны өдрөөр тогтоосугай.
9. Хурал хуралдах тухай хувьцаа эзэмшигчдэд 2020 оны 03-р сарын 20-ний өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 3-р зүйлд заасны дагуу мэдээлэхээр тогтоосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 1-ээр баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны загварыг Хавсралт 2-р баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2020 оны 04-р сарын 29-ний өдрийн 15.00 цагаар тасалбар болгосугай.
13. Энэхүү тогтоол гарсан өдрөөс хойш 3 хоногийн дотор “Хархорин ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг хурал зохион байгуулах комиссод даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П. БИШРЭЛ

“Хархорин” нээлттэй ХК-ийн ТУЗ-ийн
2020 оны 03-р сарын 16 өдрийн 02/2020 тоот
тогтоолын Хавсралт 1



“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ

“Хархорин” нээлттэй ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь дараах бичиг баримттай танилцах эрхтэй. Үүнд:

1. “Хархорин” нээлттэй ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, хавсралтууд.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс санал авах саналын хуудасны загвар.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн төсөл.
4. Хараат бус аудитын байгууллагаар баталгаажуулсан 2019 оны жилийн санхүүгийн тайлан.
5. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол.
6. “Хархорин” нээлттэй ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан.
7. “Хархорин” нээлттэй ХК-ийн 2020 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухай мэдээлэл.
8. Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой бусад баримт бичиг.

Дээрх бичиг баримттай хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид нь Хурал зохион байгуулах комисстой доорх утсаар холбогдож танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комисстой холбоо барих утас: 99993800, 94186636

Хурал зохион байгуулах комиссын хаяг: Өвөрхангай аймагт: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00. Улаанбаатар хотод: УБ хот, БЗД, 25-р хороо, 13-р хороолол, Гангар инвест ХХК-ийн байр. Ажиллах цаг: Да.- Ба. 09.00-13.00, 14.00-18.00

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

(ЗАГВАР)

“Хархорин” нээлттэй ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 14.00 цагт Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 тоот хаягаар байрлах компанийн өөрийн байрны хурлын танхимд хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар Регистрийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо Кумулятив саналын тоо

Бүртгэсэн: / БДК-ийн нэр /

Брокерын овог нэр

Ердийн аргаар санал хураах асуудлууд

Д/д	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2019 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах			
2	Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах			
3	Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг батлах			
4	Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах			

Жич: “Зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” алин болохыг чагтална / зөвхөн нэгийг нь /

Хувьцаа эзэмшигч /

Брокер /

(Хэрвээ саналаа өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан өгч байгаа бол тухайн саналын хуудсыг хүлээн авсан брокер гарын үсэг зурж тэмдэг дарсан байна)

(арын нүүрийг үзнэ үү)

САНАМЖ

“COVID-19” коронавируст халдвар дэгдсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цуглуулахгүйгээр цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулах зэргээр ээлжит хурлыг өөрийн онцлогт тохирсон боломжтой хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй гэж Санхүүгийн зохицуулах хорооноос өгч байгаа зөвлөмжийн дагуу “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигч та хуралд ирж биечлэн оролцохгүйгээр өөрийн саналаа дараах байдлаар өгөх боломжтой:

1. Хурал зохион байгуулах комиссын ganbat.battorgtokh@gmail.com цахим хаягаар өөрийн иргэний үнэмлэхний хуулбарыг илгээнэ. Хурал зохион байгуулах комисс нь Таны иргэний үнэмлэхний хуулбарыг хүлээн аваад 2020 оны 04-р сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигч мөн эсэхийг лавлаж бүртгэж авна. Асууж лавлах зүйл байгаа бол Хурал зохион байгуулах комисстой 99993800, 94186636 тоот утсаар ажлын өдрүүдэд 09.00-18.00 цагт холбогдож болно.
2. Хурал зохион байгуулах комисс нь Таны цахим шуудангийн хаягаар хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой баримт материал, саналын хуудас зэргийг pdf хэлбэрээр илгээнэ.
3. Хувьцаа эзэмшигч та хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой баримт материалтай танилцаад өөрийн саналыг хуудсыг бөглөнө. Ингэхдээ саналын хуудсыг хэвлэж өөрийн овог, нэр, регистрийн дугаар, хувьцааны тоо зэргийг бөглөнө. Үүний дараагаар санал тус бүр дээр “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” алин болохыг чагтална. Асуудал тус бүрийн “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” гэсэн саналын хувилбаруудаас зөвхөн нэгийг нь чагтална. Үүний дараагаар гарын үсгээ зурна.
4. Санал авах хуудсыг засварласан балласан тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
5. Саналын хуудсаа компанийн хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр хурал хуралдахаас ажлын 5 хоногийн өмнө хүргэж өгөх, эсхүл баталгаат шуудангаар хурал хуралдахаас ажлын 5 хоногийн өмнө “Хархорин” ХК, ХЭХ Зохион байгуулах комисс, Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар илгээнэ (Жич: саналын хуудас шуудангаар хүргэгдэхэд хугацаа орох тул ийнхүү хурал хуралдахаас ажлын 5 хоногийн өмнө шууданд өгөх нь зүйтэй).
6. Хэрвээ энэ хугацаанаас хоцорсон бол Хурал зохион байгуулах комисстой 99993800, 94186636 тоот утсаар холбогдож заавар авна.
7. Хэрвээ хувьцаа эзэмшигч нь Хурал зохион байгуулах комисстой биечлэн уулзах шаардлагатай бол тус комиссын 99993800, 94186636 тоот утсаар холбогдож цаг товлож уулзах боломжтой.